



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 21 өдөр

Дугаар А/87

Номгон

“Мал, амьтны гоц халдварт “Шүлхий” өвчнөөс
урьдчилан сэргийлэх, мэдрэмтгий мал, амьтанг
хаврын дархлаажуулалтад хамруулах ажлыг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, “Шүлхий өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай” Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2023 оны 04 дүгээр сарын 11-ны өдрийн А/87 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх хаврын дархлаажуулалтын арга хэмжээг зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр, мэдрэмтгий мал, амьтны дархлаажуулах төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Мал, амьтны гоц халдварт “Шүлхий” өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг 2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн 25 хоногийн хугацаанд батлагдсан хуваарийн дагуу, технологит хугацаанд нь шуурхай зохион байгуулж, мэргэжил арга зүй, заавар, зөвлөмжөөр хангаж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Л.Оюун-Эрдэнэ) үүрэг болгосугай.

3. Дархлаажуулалт хамрагдаж буй нутагт дэвсгэрт 28 хоногийн хугацаанд “Вакцины дархлаа” тогтох хүртлэх хугацаанд малчдын нүүдэл, малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Цагдаагийн дэд хурандаа Б.Мөнхбаяр), сум, багийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Орлогч, аймгийн Онцгой комиссын ~~Төв шуурхай~~ штаб хариуцсан орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

642310595

141
Аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр
сарын 21-ний өдрийн 112/21 дугаар захирамжийн
1 дүгээр хавсралт

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГИЙН
ТАМГЫН ГАЗАР

УДИРДАМЖ

2023 оны 04 дүгээр сарын 21

Номгон

Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс
урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг
зохион байгуулах тухай

НЭГ. ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО

Дархлаажуулалт нь мал, амьтны гоц халдварт шүлхий өвчинтэй тэмцэх, эмгэг төрүүлэгчийн дамжин халдварлалтыг бууруулах, эмнэлзүйн шинж тэмдэг үзүүлж өвчлөхөөс хамгаалах, эмгэг төрүүлэгч үржин олширч гадагшлахыг бууруулах үйл ажиллагаа юм.

Яаралтай дархлаажуулалт нь өвчин дэгдэх, гаднаас нэвтрэх эрсдэл нэмэгдэх, дахин сэргэх үеийн яаралтай арга хэмжээнд хэрэглэх вакцинжуулалтыг хэлнэ.

Дараах хүчин зүйлүүд нь энэхүү арга хэмжээг хэрэгжүүлэх үндэслэл, зорилго болсон. Үүнд:

1. Үхэр, гахай, сарлаг нь өрхийн болон улс орны эдийн засгийн хувьд өндөр ашиг шимтэй

2. Үхэр, гахай нь шүлхий өвчний халдвар тараах хамгийн өндөр идэвхтэй (судалгаагаар нэг үхэр нь 3 малд, 3 үхэр нь 9 малд хал идэвхтэй)

3. Үхэр нь шүлхий өвчинд хамгийн мэдрэмтгий, өвчний шинж тэмдэг нь хурц тод илэрдэг зэргийг харгалзан сүргийн дотор уг өвчний халдвар тархах эрсдэл, улсын хэмжээнд шүлхий өвчний тархалтыг бууруулах, зогсооход чиглэсэн нь энэхүү ажлын үндэслэл, зорилго болно.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА

1. Дархлаажуулалтын арга хэмжээнд 20 сумыг хамруулан 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрөөс нэгдсэн байдлаар улсын хэмжээнд 25 хоногийн хугацаанд шуурхай хэрэгжүүлэх.

ГУРАВ. ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГА

1. Мал эмнэлгийн ерөнхий газар нь улсын хэмжээнд хэрэгжүүлэх дархлаажуулалтын арга хэмжээг төлөвлөж, зохион байгуулах, гүйцэтгэлийг үнэлэх, хяналт тавих;

2. Аймгийн Мал эмнэлгийн газар нь тухай аймгийн хэмжээнд дархлаажуулалтын арга хэмжээг төлөвлөж, зохион байгуулах, гүйцэтгэлийг үнэлэх;

3. Сумын Мал эмнэлгийн тасаг нь тухайн сумын хэмжээнд дархлаажуулалтын арга хэмжээг төлөвлөж, зохион байгуулах, гүйцэтгэлийг үнэлэх;

4. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж, гэрээт малын эмч нь тарилгын арга хэмжээг хууль, тогтоомж, заавар, зааварчилгааны дагуу гүйцэтгэх;

5. Сумын онцгой комисс, сумын Засаг даргын тамгын газар, багийн Засаг дарга нар нь дархлаажуулалтын зар тараах, хамруулах малыг бэлэн байлгах, дархлаажуулалтын зураглал гаргахад айл өрхийн байршил, малын тоо нарийвчилсан зураглал гаргахад дэмжлэг үзүүлэх зэргээр хамтран ажиллана.

ДӨРӨВ. ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ

1. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх “арриах вак” эсийн өсгөвөрт, идэвхгүйжүүлсэн, цийдмэг вакциныг хэрэглэх заавар, МЭЕГ-ын даргын баталсан стандарт ажиллагааны зааварчилгаа (САЗ)-г баримталж тарилгын арга хэмжээг гүйцэтгэнэ.

2. Тарилгад Монгол улсын нийт үхэр, сарлаг, гахай нэг тунгаар таригдана.

3. Аймгийн мал эмнэлгийн газар, сумын МЭТ-аас тарилгын явц, гүйцэтгэлд хяналт тавихаар томилогдсон ажлын хэсэгт вакцины заавар, зөвлөмжийг сайтар танилцуулах;

4. Хяналтын ажлын хэсэг нь вакцины хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтийн горим зөрчигдөж байгаа эсэх, тарилгын явцад технологийн алдаа гарч байгаа эсэх, орхигдсон айл өрх, мал байгаа эсэх, тарилгыг зураглалын дагуу гүйцэтгэж суурийн малд эмнэлзүйн үзлэг хийж байгаа эсэхийг сайтар нягтлах;

5. Дархлаажуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэхдээ цаг агаарын байдалтай холбогдуулан багийн гишүүдийн аюулгүй байдлыг сайтар хангасан байхаар арга хэмжээг зохион байгуулах;

6. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээ хэрэгжүүлэх зураглалыг сум болон багийн түвшинд гаргаж, зураглалын дагуу тарилгын ажлыг гүйцэтгэх (САЗ-д заасан);

7.Тухайн вакцины хэрэглэх заавар болон хадгалах, тээвэрлэх нөхцөлийн талаар мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарт тусгайлан танилцуулж, гарын үсэг зуруулж, баталгаажуулах;

8.Дархлаажуулалтын арга хэмжээнд хамрагдах өрх бүрийн гадна хашаа, саравчинд тарихаар зохион байгуулна. Тарилгын нэг цэгт 1-ээс дээш өрхийн малыг цуглуулж тарихыг хориглох;

9.Дархлаажуулалт хийгдэж буй тухайн сум, баг, хорооны эрсдэл бүхий нутагт байгаа өөр аймаг, сумаас оторлож яваа малыг тарилгад хамруулах ажлыг зохион байгуулах;

10.Дархлаажуулалтын арга хэмжээнд автомат тариур хэрэглэхээс зайлсхийж аль болох нэг удаагийн тариур ашиглах; Автомат тариур ашигласан тохиолдолд хий сорогдох, дутуу болон гадуур нь шахагдах зэрэг алдаанаас зайлсхийх, нэг өрхөд ашигласан тариурын зүүг дараагийн өрхөд ашиглахгүй байх, өрх бүрийн малыг дархлаажуулахын өмнө тодорхой тооны малд тарилга хийж алдаа гарч байгаа эсэхийг шалгах;

11.Вакциныг малчинд үлдээх, мал, амьтан эмчлэх итгэмжлэлгүй этгээд, байцаагчийн дүгнэлтгүй мал эмнэлгийн үйлчилгээ эрхлэгч, алдаа гаргасан малын эмч нар тарилга хийхийг хориглох, дархлаажуулсны дараа дахин өвчлөл бүртгэгдсэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу арга хэмжээг хэрэгжүүлэх;

12.Дархлаажуулалтын арга хэмжээний талаар зохих мэдээлэл, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зөвлөмжийг малчдад өгөх;

13.Вакциныг хэрэглэх зааварт заасан дархлаа бүрэн дархлаа тогтох хугацаа /28 хоног хүртэл тарилгад хамрагдсан өрх нь отор нүүдэл хийхгүй байх анхааруулгыг малчдад өгөх (САЗ-д заасан);

14.Дархлаажуулсан малыг ялган тэмдэглэх/малчдаар будах бэлдүүлэх, будуулах, үс ноосыг хяргах гэх мэтээр/ өрхийн малын эрүүл мэндийн дэвтэрт бичилт хийх, Малын нэгдсэн цахим системд мэдээллийг малчны хотноос заавал оруулах, тарилгын явцад шүлхий болон бусад халдварт өвчний шинж тэмдэгийн үзлэг, ажиглалтын арга хэмжээг хэрэгжүүлэх /САЗ-д заасан/

ТАВ. ТАЙЛАГНАХ

1.Дархлаажуулалтын арга хэмжээнд үхэр сүргээ бүрэн хамруулах шаардлагыг тавьж, хэрэгжүүлэх;

2.Дархлаажуулалтын ажлыг дүгнэхдээ малын тооны статистик мэдээлэл болон дархлаажуулалтад хамрагдсан малын мэдээллийг тулган нягтлах, зөрүү

гарсан тохиолдолд шалтгааныг тодруулж цахим системийн үр дүн оруулах хэсгийн тодруулга хэсэгт тэмдэглэх (САЗ-д заасан);

3.Аймгийн МЭГ-н мэдээ, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн дархлаажуулалтын өдөр тутмын болон нөхцөл байдлын мэдээллийг тарилга эхэлсэн өдрөөс хойш цахимаар илгээсэн хүснэгтийн дагуу өдөр бүрийн 14:30 цагт багтаан Delgerdalai@bkh.vet.gov.mn цахим хаягаар илгээх

4.Отор нүүдлээр яваа малчдад нутаг сэлгэхдээ анхаарах асуудлаар тусгайлсан зөвлөмж өгөх, тухайн өрхийн бүх үхэр, сарлаг, гахайг дархлаажуулалтад бүрэн хамруулах;

5.Тарилгын цуваа нэг бүрийн дүнг хянаж магадлах, малчдын тамгыг бүрэн даруулсан байх шаардлага тавих;

6.Дархлаажуулалтын явцад гарсан зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх, холбогдох арга хэмжээг хуулийн дагуу авч ажиллах;

7.МЭҮН-ийн эмч нь тарилгын материалыг тарилга дууссанаас хойш 15 хоногийн дотор МЭТ ирүүлсэн байх;

8.Тарилгын гүйцэтгэлд Мал эмнэлгийн улсын байцаагч технологийн хяналт тавьж ажиллах, дархлаажуулалтын ажлын илтгэх хуудас (нэгдсэн тайлан)-ыг Adiyasuren@bkh.vet.gov.mn цахим хаягаар ирүүлэх зэргээр тайлагнаж ажиллана.


ЗУРГАА. ХАРИУЦЛАГА

1.Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нар дархлаажуулалтад хамрагдаж буй малчин өрхийн үхэр сүргийг бүрэн хамруулаагүйгээс шалтгаалан өвчлөл гарсан тохиолдолд

2.Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч дархлаажуулалтын явцын хяналт тавиагүй дүгнэлт гаргасан тохиолдолд хуулийн дагуу хариуцлага тооцно.

-----oOo-----

Аймгийн Засаг даргын ... дугаар захирамжийн 2 дугаар хавсралт
 өдрийн ... дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



ШҮЛХИЙ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ДАРХЛААЖУУЛАЛТЫН
 ТӨЛӨВЛӨГӨӨ, ХУВААРЬ

| Д/д | Сумын нэр | Өрхийн тоо | Хаврын дархлаажуулалт | | | | | | |
|-------------|-------------|--------------|-----------------------|------------|--------------------------|--------------------|--|-----------|------------|
| | | | Үхэр | Гахай | Хамрагдах нийт малын тоо | Олгох вакцин | | | |
| | | | | | | Олгох вакцин /Тун/ | Тайлбар | Хайрцаг | Шил |
| 1 | Баянхонгор | 280 | 19676 | 200 | 19876 | 20000 | | 8 | |
| 2 | Баацагаан | 319 | 4396 | | 4396 | 5000 | Отор нүүдэл- 400 үхэр /Ховд, Баян-Өлгий/ | 2 | |
| 3 | Баянбулаг | 258 | 6969 | | 6969 | 7000 | | 2 | 20 |
| 4 | Баянговь | 105 | 1240 | | 1240 | 1200 | | | 12 |
| 5 | Баянлиг | 144 | 1179 | | 1179 | 1200 | | | 12 |
| 6 | Баян-Овоо | 364 | 6829 | | 6829 | 7000 | | 2 | 20 |
| 7 | Баян-Өндөр | 81 | 494 | | 494 | 400 | | | 4 |
| 8 | Баянцагаан | 179 | 1497 | | 1497 | 1500 | | | 15 |
| 9 | Богд | 277 | 5947 | | 5947 | 6000 | | 2 | 10 |
| 10 | Бөмбөгөр | 305 | 5671 | | 5671 | 5700 | | 2 | 7 |
| 11 | Бууцагаан | 604 | 6004 | 20 | 6024 | 6100 | | 2 | 11 |
| 12 | Галуут | 924 | 38956 | | 38956 | 39100 | | 15 | 16 |
| 13 | Гурванбулаг | 581 | 16790 | | 16790 | 16800 | | 6 | 18 |
| 14 | Жаргалант | 679 | 32113 | | 32113 | 32200 | | 12 | 22 |
| 15 | Жинст | 89 | 1945 | | 1945 | 2000 | | | 20 |
| 16 | Заг | 560 | 6761 | | 6761 | 6800 | | 2 | 18 |
| 17 | Өлзийт | 531 | 10213 | | 10213 | 10300 | | 4 | 3 |
| 18 | Хүрээмарал | 323 | 4831 | | 4831 | 4900 | | 1 | 24 |
| 19 | Шинэжинст | 34 | 371 | | 371 | 400 | | | 4 |
| 20 | Эрдэнэцогт | 1087 | 51075 | | 51075 | 51100 | | 20 | 11 |
| Нийт | | 7,724 | 222,957 | 220 | 223,177 | 224,700 | | 80 | 247 |